



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/223

Ховд

Өндөржүүлсэн бэлэн байдлын  
зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в" заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 115 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 38 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 115 дугаар тогтоолын дагуу аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг /улбар шар түвшин/-т 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цагаас эхлэн 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд шилжүүлсүгэй.

2. Захирамжийг хэрэгжүүлэн ажиллахыг Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Сумдын Засаг дарга нар, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ